

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21
4. 5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020 оо. 02. 28 № 06/687
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ж.Болормаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хуулийн дагуу үнэн зөв тооцох, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг үнэн зөв бэлтгэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын онцлог, холбогдох стандарт, хууль, дүрэмтэй нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн зарим үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагаар журмын дагуу шийдвэрлүүлэх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 07-ноос 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Мэдээлэл-Аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Ганданбаавар, аудитор Э.Отгонзаяа, шинжээч С.Наранцэцэг, Чанарын хяналтын менежер Д.Туяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Мэдээлэл-Аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, албан бус насан туршийн боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааг боловсролын хөгжлийн бодлого болон нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан орчин үеийн мэдээлэл харилцааны технологид суурилж олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулж, хүний хөгжлийг дээдлэн боловсон хүчний мэдлэг, чадварыг тасралтгүй дээшлүүлж, чадварлаг, ёс зүйтэй хамт олныг бүрдүүлэх салбарынхаа тэргүүлэгч байгууллага болно гэсэн үндсэн зорилгын дор дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

1. Байгууллагын удирдлага, дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, харилцаа, хамтын ажиллагаанд орчин үеийн менежментийн хандлагыг нэвтрүүлэх,
2. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлэх зохион байгуулах,
3. Байгууллагын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх,
4. Санхүү эдийн засгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг чанаржуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
5. Байгууллагын материаллаг бааз, техник, тоног төхөөрөмж, технологийн орчныг бэхжүүлэх,
6. Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаал цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ыг мөрдөн ажиллаж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acoulous” програм хангамж ашигладаг байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд аудитын 5 чиглэлд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,319,784.5 мянган төгрөгөөс тооцон 26,395.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээг хэвээр авч 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,762,559.5 мянган төгрөгөөс 2 хувиар тооцож материаллаг байдлын түвшнийг 75,251.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 191,764.0 мянган төгрөгөөр буюу 3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	60,092.2	34,620.5	-25,471.6
Бараа материал	81,820.9	44,837.2	-36,983.7
Үндсэн хөрөнгө	6,386,463.9	6,194,699.8	-191,764.0
Нийт хөрөнгө	6,528,377.0	6,274,157.7	-254,219.3
Өр төлбөр	13,678.4	0.0	-13,678.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,514,698.6	6,274,157.7	-240,540.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,528,377.0	6,274,157.7	-254,219.3

Авлага дансны үлдэгдэл буурсан нь урьд онд үүссэн НДШ-ийн илүү төлөлтийг суутгуулж авлагыг бууруулсан, бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь урьд оны үлдэгдлээс зарцуулсан нь нөлөөлсөн.

Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө дансны үлдэгдэл нь тайлант хугацааны хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан. Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн одоо ашиглаж байгаа зарим үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгүүд нь элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн ч өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвийн ашиглаж байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд хувь хүний орлогын албан татварын өглөг болон нэр данс зөрүүтэйгээс эргэж орж ирсэн төлбөрийг тайлант хугацаанд шилжүүлээгүйгээс үүссэн байсан өр төлбөрийг 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгсний дагуу барагдуулж тайлант онд өр төлбөр үүсгэхгүй ажилласан нь шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,274,157.7 мянган төгрөг болж 240,540.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүн буурсантай холбоотой.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн үндсэн үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс 1,141,474.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоор 6,240.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,143,560.7 мянган төгрөгийг зарцуулж 4,153.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 2 байгууллагаас 26,530.9 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 950,031.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,392,166.8 мянга, нийт 2,368,728.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 563,483.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 55,156.7 мянга, хангамж бараа материалын зардалд 37,703.8 мянга, томилот зочны зардалд 6,293.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 2,100.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,669,013.1 мянга нийт 2,333,750.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 34,978.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж 1 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 766.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх аудитын зөвлөмжийг менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээлэл байршуулахаас 123 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 54,011.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Татварын тооцоолол, тайлагнал

3.1.1 Илрүүлэлт:

Ажиллагсдын цалингаас суутгах Хувь хүний орлогын албан татварыг 61.6 мянган төгрөгөөр зөрүүтэй суутгасан байна. Энэ нь “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хувь хэмжээг баримтлаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

- Татварын тайлан буруу илэрхийлэгдэх,

3.1.3 Өгсөн зөвлөмж

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг мөрдөж, татварын хөнгөлөлтийн тооцоог үнэн зөв хийх,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цалингийн програмд ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцооллын томьёо нь зөрүүтэй байснаас үүссэн. Татварын хөнгөлөлтийн томьёог “Санхүүгийн тооцоолох групп ХХК”-аар засварлуулна.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээрх нийт зардал нь нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаарх нийт цалингийн дүнгээс 705.2 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан ажил олгогчийн үүргийг биелүүлээгүй.

3.2.2 Эрсдэл:

- Өглөг авлага буруу илэрхийлэгдэх,

3.2.3 Өгсөн зөвлөмж

- Тооцсон нийт цалингийн мэдээллийг нийгмийн даатгалын цахим системд зөв тайлагнаж байх,

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2020 оны 1 дүгээр улиралд нийгмийн даатгалын тайланг залруулна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт

Одоогийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим дансны код нь Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” журмын 1 дүгээр хавсралтаас зөрүүтэй байна. Энэ нь “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2-д Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг нь "... байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтыг зөрчсөн.

3.3.2. Эрсдэл:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, УСНББОУС, Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа, холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцэхгүй байх,

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын онцлог, холбогдох стандарт, хууль журмыг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах,

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээд газраас батлан гаргасан тушаал, шийдвэр, тогтоолын өөрчлөлтийг тухай бүрд бүртгэлдээ хэрэгжүүлдэг бөгөөд байгууллагад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлтийг нэмэлтээр тусган цаашид мөрдөж ажиллана.

3.4 Санхүүгийн тайлантай холбоотой

3.4.1 Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийн бүртгэлд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ч ашиглагдаж байгаа хөрөнгө нийт үндсэн хөрөнгийн 8.1 хувийг эзэлж байна. Энэ нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл

- Хөрөнгийн өнөөгийн үнэ цэн бодитой бус байх,

3.4.3 Өгсөн зөвлөмж

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7.1-д заасны дагуу шийдвэрлүүлэх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг актлах болон дахин үнэлэх ажлыг шат дараатайгаар зохион байгуулна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	141,913,113.49	79,457,805.03
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
33	АВЛАГА	60,092,189.09	34,620,547.97
33300	Татаас, санхүүжилтийн авлага	19,208,634.00	34,615,864.08
335	Бусад авлага	40,883,555.00	4,683.89
3351	Байгууллагаас авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	81,820,924.40	44,837,257.06
351	Түүхий эд материал	17,294,590.00	13,901,890.00
35110	Тусгай зориулалттай материал	17,294,590.00	13,901,890.00
354	Хангамжийн материал	64,526,334.40	30,935,367.06
35410	Бичиг хэргийн материал	33,330,050.00	4,380,000.00
35420	Аж ахуйн материал	29,766,284.00	24,925,367.06
35430	Сэлбэг хэрэгсэл	1,430,000.00	1,430,000.00
35440	Түлш шатах тослох материал	-	200,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,386,463,913.08	6,194,699,878.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,386,463,913.08	6,194,699,878.23
392	Биет хөрөнгө	6,386,304,833.08	6,194,699,878.23
39201	Барилга, байгууламж	6,195,347,418.00	6,195,347,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-95,313,037.20
39203	Авто тээврийн хэрэгсэл	173,811,653.00	173,811,653.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-147,155,107.00	-173,811,653.00
39205	Машин, тоног төхөөрөмж	421,396,092.00	421,396,092.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-366,923,140.00	-412,238,408.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,201,022.00	243,201,022.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-133,500,096.00	-157,820,198.23
39217	Номын фонд	126,990.00	126,990.00
393	Биет бус хөрөнгө	159,080.00	-
39301	Програм хангамж	8,762,400.00	8,762,400.00
39302	Хасагдуулга	-8,603,320.00	-8,762,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,528,377,026.57	6,274,157,683.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	13,678,440.38	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,678,440.38	-
413	Өглөг	10,265,399.38	-
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	10,265,399.00	-
4136	Бусад өглөг	3,413,041.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	3,413,041.00	-
41362	Хувь хүмүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	6,514,698,586.19	6,274,157,683.76
51	Засгийн газрын хувь оролцоо	6,514,698,586.19	6,274,157,683.76

511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	6,615,693,446.20	6,615,693,446.20
51101	Өмч: -Төрийн өмч	6,615,693,446.00	6,615,693,446.20
512	Хуримтлагдсан үр дүн	-1,065,961,875.51	-1,306,502,778.44
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,065,961,875.51	-1,065,961,875.51
51220	Тайлант үеийн үр дүн	-	-240,540,902.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	964,967,016.00	964,967,016.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	6,528,377,026.57	6,274,157,683.76

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,497,860,383.00	3,530,079,809.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,238,746.00	19,876,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,238,746.00	19,876,200.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	29,238,746.00	19,876,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,090,220.00	6,285,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,148,526.00	13,591,200.00
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,468,621,637.00	3,510,203,609.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,070,136,500.00	1,141,474,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,070,136,500.00	1,141,474,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,398,485,137.00	2,368,728,909.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	117,977,285.00	26,530,975.41
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	1,280,440,352.00	950,031,156.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	67,500.00	1,392,166,777.99
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,723,246,126.00	3,770,620,712.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,723,246,126.00	3,770,620,712.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,684,377,177.00	3,762,559,474.40
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	776,485,698.00	1,344,548,962.35
210101	Цалин	729,973,798.00	1,210,370,446.35
210102	Нэмэгдэл цалин	13,711,900.00	47,773,516.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,800,000.00	86,405,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,951,858.00	176,850,861.19
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	66,607,089.00	145,347,918.19
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,836,192.00	7,947,037.75
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,268,954.00	6,326,911.40
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	567,238.00	1,566,271.35
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,672,385.00	15,662,722.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,802,502.00	161,012,600.40
210301	Гэрэл цахилгааны зардал	116,119,992.00	120,038,299.16
210302	Түлш, халаалтын зардал	27,231,367.00	31,723,701.24
210303	Цэвэр, бохир усны зардал	7,451,143.00	9,250,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	155,387,243.00	136,219,611.00
210401	Бичиг хэргийн материал	119,517,601.00	92,983,945.00
210402	Тээвэр, шатахууны зардал	8,770,500.00	7,793,100.00

210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	9,897,613.00	13,398,219.60
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	2,202,984.00	1,670,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	14,998,545.00	19,989,346.40
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	385,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,619,831.00	29,631,800.00
210604	Урсгал засвар	7,619,831.00	29,631,800.00
2107	Томилолт, зочны зардал	368,350,250.00	4,198,620.00
210702	Дотоод томилолтын зардал	368,350,250.00	4,198,620.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	121,152,215.00	52,035,978.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,789,215.00	42,405,978.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	4,000,000.00	6,900,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	363,000.00	2,730,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,026,627,582.00	1,858,061,041.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,166,662.00	10,265,399.38
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	763,778,613.00	1,656,031,607.23
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	260,682,307.00	191,764,034.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,868,949.00	8,061,237.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,454,400.00	3,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,454,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,414,549.00	4,561,237.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,414,549.00	4,198,966.53
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		362,271.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-225,385,744.00	-240,540,902.93
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	-225,385,744.00	-240,540,902.93

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,501,643,594.67	3,516,488,609.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,756,079.00	6,285,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	31,756,079.00	6,285,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	31,756,079.00	6,285,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,090,220.00	6,285,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,665,859.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,469,887,515.67	3,510,203,609.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,070,136,500.00	1,141,474,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,070,136,500.00	1,141,474,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,399,751,015.67	2,368,728,909.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	117,977,284.67	26,530,975.41
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон санхүүжилт	1,280,440,352.00	950,031,156.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,333,379.00	1,392,166,777.99
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,501,673,193.77	3,516,488,609.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,501,673,193.77	3,516,488,609.40
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,443,595,610.44	3,473,811,507.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	813,913,959.91	1,344,548,962.35
210101	Үндсэн цалин	733,354,613.91	1,210,370,446.35
210102	Нэмэгдэл	20,163,546.00	47,773,516.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,395,800.00	86,405,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,235,570.41	136,031,301.04
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	49,185,356.00	105,579,820.47
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	25,050,214.41	7,032,902.40
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	5,443,858.89
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	1,265,075.48
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	16,709,643.80
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	150,802,501.89	160,802,400.40
210301	Гэрэл цахилгааны зардал	116,119,992.00	120,038,299.16
210302	Түлш, халаалтын зардал	27,231,367.00	31,571,201.24
210303	Цэвэр, бохир усны зардал	7,451,142.89	9,192,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,229,214.07	69,291,307.60
210401	Бичиг хэрэг	41,284,463.10	40,644,051.00
210402	Тээвэр, шатахуун	6,243,000.00	8,655,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,957,612.97	12,048,219.60

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,202,984.00	1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,541,154.00	6,144,037.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,457,800.00	14,960,476.00
210604	Урсгал засвар	5,457,800.00	14,960,476.00
2107	Томилолт, зочны зардал	368,623,850.00	15,979,700.00
210702	Дотоод албан томилолт	368,623,850.00	15,979,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,433,414.61	63,184,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	117,658,414.61	52,377,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	6,900,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,775,000.00	3,907,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	836,899,299.55	1,669,013,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,166,662.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	834,732,637.55	1,669,013,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,077,583.33	42,677,102.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,454,400.00	3,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,454,400.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		3,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг	31,623,183.33	39,177,102.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,623,183.33	4,198,966.35
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		34,978,135.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-29,599.10	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-29,599.10	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,599.10	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан тайлан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
1	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,615,693,446.20	0	-840,576,131.78	5,775,117,314.42
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,615,693,446.20	0	-840,576,131.78	5,775,117,314.42
4	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0	0	0	0
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
7	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	-225,385,743.73	-225,385,743.73
8	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	-1,065,961,875.51	6,514,698,586.19
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	-1,065,961,875.51	6,514,698,586.19
11	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0	0	0	
12	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0	0	0	0
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0	0	0	0
15	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	-240,540,902.93	-240,540,902.93
16	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	-1,306,502,778.44	6,274,157,683.26

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,147,714,700.00	1,143,560,733.47	4,153,966.53	99.6
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,147,714,700.00	1,143,560,733.47	4,153,966.53	99.6
210	Бараа, үйлчилгээний зардал	1,144,214,700.00	1,140,060,733.47	4,153,966.53	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	782,163,100.00	781,065,405.43	1,097,694.57	99.9
210101	Үндсэн цалин	647,575,000.00	646,886,889.43	688,110.57	99.9
210102	Нэмэгдэл	47,857,600.00	47,773,516.00	84,084.00	99.8
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	86,730,500.00	86,405,000.00	325,500.00	99.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,895,300.00	80,874,604.04	3,020,695.96	96.4
210201	Тэтгэврийн даатгал	52,248,900.00	52,245,004.47	3,895.53	100
210202	Тэтгэмжийн даатгал	7,911,600.00	6,553,460.40	1,358,139.60	82.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,329,300.00	5,060,304.89	1,268,995.11	80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,582,300.00	1,265,075.48	317,224.52	80
210205	Эрүүл мэндийн даатгал	15,823,200.00	15,750,758.80	72,441.20	99.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,802,500.00	160,802,400.40	99.60	100
210301	Гэрэл цахилгаан	120,038,300.00	120,038,299.16	0.84	100
210302	Түлш, халаалт	31,571,300.00	31,571,201.24	98.76	100
210303	Цэвэр, бохир ус	9,192,900.00	9,192,900.00	0.00	100
2104	Хангамж, бараа материалын зардал	31,589,400.00	31,587,447.60	1,952.40	100
210401	Бичиг хэрэг	8,391,800.00	8,391,791.00	9.00	100
210402	Тээвэр (шатахуун)	4,780,000.00	4,780,000.00	0.00	100
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	12,048,200.00	12,048,219.60	-19.60	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	1,800,000.00	0.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,569,400.00	4,567,437.00	1,963.00	100
2106	Эд хогшил худалдан авах	14,960,500.00	14,960,476.00	24.00	100
210604	Урсгал засвар	14,960,500.00	14,960,476.00	24.00	100
2107	Томилолт, зочны зардал	9,686,200.00	9,686,200.00	0.00	100
210702	Дотоод албан томилолт	9,686,200.00	9,686,200.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	61,117,700.00	61,084,200.00	33,500.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,277,200.00	50,277,200.00	0.00	100
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	6,930,000.00	6,900,000.00	30,000.00	99.6
210806	Мэдээллийн технологийн зардал	3,910,500.00	3,907,000.00	3,500.00	99.9
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,500,000.00	3,500,000.00	0.00	100

2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	3,500,000.00	0.00	100
213207	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,500,000.00	3,500,000.00	0.00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,147,714,700.00	1,143,560,733.47	4,153,966.53	99.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,141,474,700.00	1,137,275,733.47	4,198,966.53	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,141,474,700.00	1,137,275,733.47	4,198,966.53	99.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,240,000.00	6,285,000.00	-45,000.00	100.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,240,000.00	6,285,000.00	-45,000.00	100.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	70	67	3	95.7
620001	Удирдах ажилтан	2	2	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	49	44	5	89.8
620003	Үйлчлэх ажилтан	19	21	-2	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	2,368,728,909.40
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	0.00	2,368,728,909.40
210	Бараа, үйлчилгээний зардал	0.00	2,333,750,773.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	563,483,556.92
210101	Үндсэн цалин	0.00	563,483,556.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	55,156,697.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	53,334,816.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	479,442.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	383,554.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	958,885.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	37,703,860.00
210401	Бичиг хэрэг	0.00	32,252,260.00
210402	Тээвэр (шатахуун)	0.00	3,875,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	0.00	1,576,600.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	6,293,500.00
210702	Дотоод албан томилолт	0.00	6,293,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	0.00	2,100,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	0.00	2,100,000.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,669,013,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,669,013,160.00
213	Урсгал шилжүүлэг	0.00	34,978,135.48.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	34,978,135.48.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	2,368,728,909.40
1311	Нэмэлт сахнүүжилтийн орлого	0.00	2,368,728,909.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	26,530,975.41
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	950,031,156
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,392,166,777.99

4. 5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.18	Аудитын нэр: Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/114/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажиллагсдын цалингаас суутгах Хувь хүний орлогын албан татварыг 61.6 мянган төгрөгөөр буруу тооцож суутгасан.	61.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	У.Золзаяа
2	Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээрх дүн нийгмийн даатгалын тайлангаарх нийт цалингийн дүнгээс 705.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	705.2	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	У.Золзаяа
3	Байгууллагын одоогийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим дансны код нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаас зөрүүтэй байна.	-	Зөвлөмж өгөх	БМДИ-ийн захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Болормаа У.Золзаяа
4	Үндсэн хөрөнгийн бүртгэлд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ч ашиглагдаж байгаа хөрөнгө нийт үндсэн хөрөнгийн 8.1 хувийг эзэлж байна.	-	Зөвлөмж өгөх	БМДИ-ийн захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Болормаа У.Золзаяа
	Дүн	766.8			

